



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2018.02.09 № 11

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ
ТАНАА

Асуулга тавих тухай

Монгол Улсын Их Хурлын гишүүн миний бие УИХ-ын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайд Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

Хэнтий аймгийн Бэрхийн уурхай нь анх 1954 оны 09 дүгээр сарын 12-нд Зөвлөлт-Монголын хувь нийлүүлсэн “Совмонголметалл” нийгэмлэгийн шийдвэрээр байгуудагдсан. 1955-1957 онуудад ЗХУ-ын геологи хайгуулын 229-р анги нарийвчилсан хайгуул хийж Бэрхийн хайлуур жоншны орд нь нөөц, чанар эрдэс баялгийн агуулгын хувьд дэлхийд дээгүүр орох орд болохыг тогтоосон.

1957-1973 он хүртэл Зөвлөлт-Монголын хувь нийлүүлсэн “Совмонголметалл” нийгэмлэг түүхэн үүргээ гүйцэтгэж 1973 оноос Аж үйлдвэрийн яамны харъяанд ажиллаж жилд 40,0 тонн экспортын жонш олборлох хүчин чадалтай, 1983 оноос жилд 180,0 тонн экспортын жонш олборлох хүчин чадалтай тус үйлдвэрийн олборлосон экспортын жоншны чанар хэмжээ байнга өсөн нэмэгдэж 3,5 сая тонн өндөр чанарын жонш олборлон улсын экспортын бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэхэд онцгой чухал үүрэг гүйцэтгэж ирсэн тул 1971 онд Төрийн дээд шагнал “Алтан гадас” одонгоор шагнагдсан 63 жилийн түүхтэй уурхай.

2012 онд “Файрборд глобал мастер фанд” ХХК худалдан авч 100 хувь эзэмшихээр болсон ч одоогийн байдлаар нэг ч үйл ажиллагаа явуулаагүй байгаа нь уурхай түшиглэн байгуулагдсан Бэрх хотын 3600 гаруй иргэдийн аж амьдралд сөргөөр нөлөөлж хөдөлмөрийн насны залуучуудын 50-иас илүү хувь нь ажилгүй байгаа нь нэн харамсалтай асуудал юм.


1. Бэрхийн уурхайн хувьчлалын талаар;
2. Бэрхийн 194 уурхайчдын нөхөн олговрын асуудлыг хэрхэн шийдэх талаар;
3. Цаашид Бэрхийн жоншны уурхайг ажиллуулах талаар Засгийн газраас авч

0000000070

хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зэрэг болно.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3-т заасны дагуу албан бичгээр ирүүлж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар сонсгохыг хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Л.ОЮУН-ЭРДЭНЭ
Х.НЯМБААТАР